



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/312

Хэрлэн сум

Үнэ бууруулж худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.2 "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 88 дугаар тогтоолоор батлагдсан эд хөрөнгийн харилцааг зохицуулах журмын 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалтхаан сумын эрүүл мэндийн төвийн 41,360,900 төгрөгийн балансын үнэтэй, үлдэх өртөггүй хөрөнгийг дуудлагын худалдаагаар үнэ бууруулж худалдахыг хавсралтаар баталсугай.

2. Нээлттэй дуудлагын худалдааг үнэ бууруулж зохион байгуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Ц.Дэмбэрэлсайхан	-Орон нутгийн өмчийн газрын дарга
Хөтлөгч:	С.Энхцэцэг	-Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
Тэмдэглэл хөтлөгч:	Л.Оюунтуяа	-Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч, бичиг хэрэг

3. Нээлттэй дуудлагын худалдааг үнэ бууруулж 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 10:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 304 тоот өрөөнд зохион байгуулсугай.


4. Нээлттэй дуудлагын худалдааг үнэ бууруулж хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

03  
 Аймгийн Засаг даргын 2018 оны  
 дугаар сарын 17-өдрийн 1/312  
 дугаар захирамжийн хавсралт



ҮНЭ БУУРУУЛЖ ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр /товч мэдээлэл/	Монгол Улсад орж ирсэн огноо	Нэгдсэн эмнэлэг худалдаж авсан огноо	Нэгдсэн эмнэлэг Жаргалтхаан сумын ЭМТөврүү шилжүүлсэн огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Хурамтлагдсан эзлэгдэл	үлдэх өртөг	Худалдааны үнийн санал		
										Анх тогтоосон үнэ	Буурсан үнэ	Үүнээс Аймгийн төсөвт
1	Жаргалтхаан ЭМТөв	DONGFENG 74-86 ХЭҮ	2010.03.24	2011.06.15	2016.06.17	1	41,306,900	41,306,900	0	3,500,000	1,750,000	1,750,000
Дүн							41,306,900	41,306,900		3,500,000	1,750,000	1,750,000